



**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН
НЭГДСЭН ЦЕХИЙН ТАРИФ МЭРГЭЖЛИЙН
ЛАВЛАХ**

Улаанбаатар хот

2018 он

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН НЭГДСЭН ЦЕХИЙН
ДХХА-ИЙН ХЭСГИЙН ДХХА-ИЙН ЗАСВАРЧИНЫ III ЗЭРГИЙН
АЖЛЫН БАЙРНЫ ТАРИФ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ-7126-21**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Эрчим хүчний инженерийн бакалавраас доошгүй зэрэгтэй, тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж үнэлэлт гаргах, орчин үеийн техник хэрэгслийг ажлын байранд сайн ашиглах, харилцааны ур чадвартай, гарч буй өөрчлөлтөнд зохицон ажиллах чадвартай байх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, дулаан даралтын шалгалт тохируулгын эрхтэй, зураг схем унших чадвартай байх.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Дулаан үйлдвэрлэлийн процесст оролцдог үндсэн болон туслах тоноглолтуудын ажиллагааны байдал, дулаан процесийн хяналт, хэмжилтэнд ашиглагдах Хянах, хэмжих хэрэгсэлүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, тэдгээрт үзлэг, засвар, үйлчилгээ, тохируулгын ажлыг гардан гүйцэтгэнэ.

МЭДВЭЛ ЗОХИХ:

Цахилгаан техникийн үндэс, засч байгаа хэмжүүр, автомат, тохируулагчийн ажиллах зарчим, зориулалт, ган хоолойг матах, бэхлэх арга. DCS кабинетын холболтуудын алдаа, анхдагчуудаас дамжуулах 4-20 mA-н сигналуудын зөрүүг арилгах, дулааны схем дэх хамгаалах, тохируулах, хаах арматурын томъёолсон тэмдэглэл хийх арга, хий ба шингэний зарцуулалтыг хоолойн хөндлөн отглол, нарийсгагч ба дифференциал манометрээр хэмжих журам, отглол нарийсгагчийг байрлуулах ба тэнцүүлэх тусгаарлах савуудыг байрлуулах журам, импульсийн шугамыг татах, цахилгаан соронзон системийн хэмжүүрийн үлгэрчилсэн ба цахилгаан монтажийн схемүүд (догометр, гальванометр) цахилгаан хөдөлгүүрийн ороомогийн ангиллын ба хоёрдогч коммутациын энгийн хэлхээний томъёолсон тэмдэг, селен, купрокс, шулуутгагчийн ангилал, ажиллах зарчим. Эрчим хүчний үйлдвэрүүдэд мөрдөгдөх ТАД, ААД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн Хөдөлмөрийн дотоод журам, компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм журам, "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах" хууль, аргачлал, стандартууд, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомж.

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Зуухны үндсэн удирдлага DCS кабинетын холболтуудын алдаа, анхдагчуудаас дамжуулах 4-20 mA-н сигналуудын зөрүүг арилгана.
2. 10/0,4кВ -ийн цахилгаан хөдөлгүүрүүдийн удирдлагын сигнал шалгана.
3. Үндсэн ба туслах тоноглолтуудыг ажилд залгах, салгах, ашиглалтын үеийн интерлок хамгаалалтын системийг шалгах, баталгаажуулна.
4. Дулааны хянах хэмжүүрүүдэд хэмжилт хийж, шалгаж баталгаажуулна.
5. Зуухны сүлжээний усны даралт, зарцуулалтын хэмжүүрүүдэд үзлэг шалгалт хийнэ.
6. Хэмжилтийн үйл ажиллагаанд батлагдсан "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах" хууль, аргачлал, стандартуудыг мөрдөнө.

7. Ажлын байранд Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Техник ашиглалтын дүрэм, Аюулгүй ажиллагааны дүрэм зэрэг эрчим хүчний байгууллагуудад өдөр тутам мөрдөгдөх дүрэм, заавруудыг мөрдөж ажиллана.
8. Амгалан дулааны станцын захиргаанаас батлан гаргасан дүрэм, журам, заавруудыг ажлын байранд мөрдөнө.
9. Амгалан дулааны станцын дулааны процесийн хянах, хэмжих хэрэгсэлүүдийн хэвийн ажиллагааг хангаж засвар үйлчилгээ, тохируулга хийнэ.

Үүнд:

- Даралтын трансмитерүүд, дифференциал даралтын трасмитерүүд
- Термопарууд, термометр, байран дээр заагч хэмжүүрүүд, эсэргүүцэлийн термометрүүд
- Түвшний трансмитерүүд
- Алсын удирдлагтай актуаторууд, тохируултын регуляторууд
- Химийн анализаторууд

10. Анхдагч болон хоёрдогч хэлхээг шалгаж, найдвартай ажиллагааг хангаж, хэлхээний чангалаа, цэвэрлэгээ хийнэ.

11. Үндсэн ба туслах тоноглолуудыг ажилд залгах, салгах, ашиглалтын үеийн интерлок хамгаалалтын системийн найдвартай ажиллагааг хангана.

Үүнд:

- Галын хотолын температур ихсэлт.
- Галын хотолын температур бууралт.
- Галын хотолын даралт ихсэлт.
- Галын хотолын даралт багасах.
- Анхдагч агаарын зарцуулалт багасах.
- Анхдагч агаарын салхилуурын хориг.
- Утаа сорогчийн салхилуурын хориг.
- Гар MFT хориг.
- Тогооны усны температур хэт ихсэх.
- Сүлжээний усны температур хэт ихсэлт.

12. Зүүхны болон сүлжээний усны зарцуулалтын хэмжүүрүүдэд үзлэг шалгалт хийх, гарсан гэмтэл устгана.

13. Хэмжүүр болон импульсийн шугамын штуцер холболтыг шалгаж свитч устгана.

14. Импульсын шугам үлээлгэж цэвэрлэнэ.


15. Даралт зарцуулалтын хэмжүүрүүдэд “0” тохируулга хийнэ.

16. Хими анализын хэмжүүрт шалгалт тохируулга хийнэ.

17. Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолт, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусламж үзүүлэх заавруудаар тогтсон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.

18. Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск/-ийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. ААД, ТАД,

ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам,
Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг
мөрдөж ажиллана.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал  Ш.Баянмөнх  Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p>
<p>ХЯНАСАН: ДХХА-ийн хэсгийн инженер  С.Доржнамжиг Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн  Г.Саруул</p> <p>ХАБЭА-ийн инженер  А.Энхжаргал</p>	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН
НЭГДСЭН ЦЕХИЙН ДХХА-ИЙН ХЭСГИЙН ДХХА-ИЙН ЗАСВАРЧИНЫ
ИҮ ЗЭРГИЙН АЖЛЫН БАЙРНЫ ТАРИФ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ-7126-21**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Эрчим хүчний инженерийн бакалаврын зэрэгтэй, тухайн албан тушаалд 2 ба түүнээс дээш жил ажилласан, тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж үнэлэлт гаргах, орчин үеийн техник хэрэгслийг ажлын байранд сайн ашиглах, харилцааны ур чадвартай, гарч буй өөрчлөлтөнд зохицон ажиллах чадвартай байх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, дулаан даралтын шалгалт тохируулгын эрхтэй, зураг схем унших чадвартай байх.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Эд ангиудад нарийвчлалын слесарийн боловсруулалт хийх. Хэмжих багаж хэрэгслэл ашиглан дулааны хянах хэмжих хэрэгслэл ба автоматикийн төвөгтэй монтажийн ажил гүйцэтгэх, цахилгаан соронзон системийн хэмжүүрүүдийн бүх механизмууд, хөдлөх системийг задалж элэгдсэн эд ангийг солих, засварлах, градуировкийг өөрчлөх, холбоосуудад тохируулга хийх. Хэмжүүр, автоматикийн хэрэгслүүдийн паспортанд бичилт хийж гэмтлийн тодорхойлолт гаргах, DCS кабинетын холболтуудын алдаа, анхдагчуудаас дамжуулах 4-20 mA-н сигналуудын зөрүүг арилгах. Нэгдсэн цехийн дарга, ДХХА-ийн инженерийн шууд удирдлагад ажиллана. Ээлжинд ажилладаг бол станцын ээлжийн инженерийн шууд удирдлагад, өгсөн үүрэг даалгаврыг нь биелүүлж ажиллана.

МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

Механик, цахилгаан техникийн онолын үндэс ба электроникийн анхны мэдэгдэхүүн, цахилгаан багтаамж, индукци, идэвхит ба идэвхигүй эсэргүүцэл, дамжуулах чадвар зэргийн тухай ойлголт тэдгээрийн хэмжих нэгж, хэмжүүр автоматикийн хэрэгслүүдийн бүтэц, зохион байгуулалтын онцлог, задлах, угсрал засварлах, тохируулах, хэмжих хэрэгслүүдийн шалгалт, туршилтаар үнэмлэхүй ба харьцангуй алдааны хэмжээг тодорхойлох арга, дулааны ба цахилгааны схемүүд, түүний таних тэмдгүүд, дулааны хэмжүүр, автоматуудын ажиллагаанд тохиолдох гэмтлүүдийн шалтгаан, тэдгээрийг устгах, аргачлал. Бүх төрлийн манометр, хэмжүүрүүдийн цахилгаан ба кинематик схемүүд, хэмжүүрийн эд ангиудын эскиз зурах, цахилгаан хэмжигдэхүүнүүдийг хэмжих арга, электрон ламп, фотоэлемент, фото эсэргүүцэл, хагас дамжуулагчудын бүтэц, ажиллагаа, энгийн электрон схемийг унших, DCS кабинетын холболтуудын алдаа, анхдагчуудаас дамжуулах 4-20 mA-н сигналуудын зөрүүг арилгах. Мөн Эрчим хүчний үйлдвэрүүдэд мөрдөгдөх ТАД, ААД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм журам, "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах" хууль, аргачлал, стандартууд, компанийн Хөдөлмөрийн дотоод журам, компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм журам, "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах" хууль, аргачлал, стандартууд, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомж.

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Автомат тохируулагч хэрэгслүүдийн ажиллагааг ажлын байранд шалгах ба тохируулна.
2. Туузан ба шанагат дамжуулагчдын автомат жинд үзлэг, шалгалт тохируулга хийнэ.
3. Хэмжилтийн диафрагма түвшний импульс авах байгууламжуудыг монтажлана.
4. Дулааны хянах хэмжүүрийн ба цахилгааны дунд зэргийн төвөгтэй схемийг холбох, монтажлана.
5. Кабель, импульсийн шугам таталт холболтын туслах хийц хэрэгслүүдийг бэлдэх, бэхлэх, байрлуулна.
6. Потенциаметруудэд кинематик механизм ба хөдлөх системийн задаргаа, засвар хийнэ.
7. Зарцуулалтын хоёрдогч хэмжүүр, манометр, термометрийн механизмын засвар хийнэ.
8. Өөрөө бичигч хэмжүүрийн механизмын хурдны тохируулга хийнэ.
9. Цахилгаан соронзон системийн хэмжүүрүүдийн кинематик механизм ба хөдлөх системийг задалж засварлана.
10. Электрон тохируулагч хэмжүүрийн засварлана.
11. Зарцуулалтын хэмжүүрийн бичлэгийн чанар байдлыг засч тохируулна.
12. Хоёр хүртлэх хоёрдогч хэмжүүртэй зарцуулалтын хэмжих хэрэгслийг монтажлах угсрах, тохируулна.
13. Хүчдэл тогтвортжуулагчийг шалгаж засна.
14. Импульс авах хэрэгслүүдийг хийж бэлтгэнэ.
15. Хэмжилтийн үйл ажиллагаанд батлагдсан "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах" хууль, аргачлал, стандартуудыг мөрдөнө.
16. Ажлын байранд Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Техник ашиглалтын дүрэм, Аюулгүй ажиллагааны дүрэм зэрэг эрчим хүчиний байгууллагуудад өдөр тутам мөрдөгдөх дүрэм, заавруудыг мөрдөж ажиллана.
17. Амгалан дулааны станцын захиргаанаас батлан гаргасан дүрэм, журам, заавруудыг ажлын байранд мөрдөнө.
18. Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолт, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусламж үзүүлэх заавруудаар тогтсон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.

19. Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск/-ийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөж ажиллана.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал  Ш.Баянмөнх</p>
<p>ХЯНАСАН: ДХХА-ийн хэсгийн инженер  С.Доржнамжиг Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн  Г.Саруул ХАБЭА-ийн инженер  А.Энхжаргал</p>	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН
НЭГДСЭН ЦЕХИЙН ДХХА-ИЙН ХЭСГИЙН ДХХА-ИЙН ЗАСВАРЧИНЫ
Ү ЗЭРГИЙН АЖЛЫН БАЙРНЫ ТАРИФ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ-7126-21**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Эрчим хүчний инженерийн бакалавраас доошгүй зэрэгтэй, тухайн албан тушаалд 4 ба түүнээс дээш жил ажилласан, тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж үнэлэлт гаргах, орчин үеийн техник хэрэгслийг ажлын байранд сайн ашиглах, харилцааны ур чадвартай, гарч буй өөрчлөлтөнд зохицон ажиллах чадвартай байх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, дулаан даралтын шалгалт тохируулгын эрхтэй, зураг схем унших чадвартай байх.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Онцгой чухал эд ангиудыг нарийвчлалын 1-2-р ангиллаар өнгөлж слесарийн ба дулааны боловсруулалт хийж бэлтгэх, DCS кабинетын холболтуудын алдаа, анхдагчуудаас дамжуулах 4-20 mA-н сигналуудын зөрүүг арилгах, Дулааны ба цахилгааны бүх төрлийн хэмжүүр автоматикийн хэрэгслүүдийг нарийвчлалын ангиллаар нь шалгаж тохируулах. Хэмжүүр, автоматикийн хэрэгслэлүүдийн цахилгаан ба электрон характеристикуудийг тодорхойлох лабораторийн шалгалт, засварыг хийж гүйцэтгэх. Бүх төрлийн хэмжүүрүүдийг улсын шалгалтанд бэлтгэж шалгуулах. Нэгдсэн цехийн дарга, ДХХА-ийн инженер, ээлжинд ажилладаг бол станцын ээлжийн инженерийн шууд удирдлагад ажиллана.



МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

Төрөл бүрийн дулааны хэмжүүрүүд, автомат тохируулгын хэрэгслүүдийн бүтэц, хийц, зохион байгуулалтын онцлогууд. Бүх төрлийн өөрөө бичигч хэмжүүрүүдийн кинематик схемүүд, микрометр, индикатор зэрэг нарийн хэмжүүр, хэмжих хэрэгслүүдийн бүтэц зохион байгуулалт, эд ангиудын элэгдлийн хэмжээг тодорхойлох, эд ангиудын элэгдэл ба зэврэлтээс хамгаалах аргууд. Дулааны хүчний янз бүрийн тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын ажиллагааг хянахад шаардагдах бүх төрлийн хэмжүүр хэмжих хэрэгслүүдийг сонгох. Дулааны автомат тохируулагчуудыг ажлын байранд шалгах, тохируулах, DCS кабинетын холболтуудын алдаа, анхдагчуудаас дамжуулах 4-20 mA-н сигналуудын зөрүүг арилгах. Мөн Эрчим хүчний үйлдвэрүүдэд мөрдөгдөх ТАД, ААД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм журам, "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах" хууль, аргачлал, стандартууд, компанийн Хөдөлмөрийн дотоод журам, компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм журам, "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах" хууль, аргачлал, стандартууд, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомж.

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Автомат тохируулагчууд ба бусад электрон хагас дамжуулагч схемтэй аппаратуудыг засварлах шинэчлэн өөрчлөнө.
2. Автомат тохируулагчууд хэмжүүрүүдийг монтажлах, тохируулна.
3. Автомат тохируулагчууд, хэмжүүрүүдийн гэмтлийг ажлын байранд олж илрүүлнэ.
4. Хий шинжлэгчүүд, хүчилтөрөгчийн хэмжүүрийг шалгах засварлана.

5. Цахилгаан-механик, автомат, электрон мост потенциометрүүдийн градуировкийг өөрчлөн тохируулах, засварлана.
6. PH метрүүдийг бүрэн задлах, угсрах, засварлана.
7. Бүх төрлийн зарцуулалтын хэмжүүрүүдийг улсын шалгалтанд бэлдэх ба шалгуулна.
8. Цахилгаан схемүүдийг монтажийн дараа шалгаж туршина.
9. Удирдах пульттэй олон самбарт щитийг зоож байрлуулах, угсарна.
10. Дулааны хяналтын нарийн төвөгтэй схемийг щитэнд монтажлана.
11. DCS кабинетын холболтуудын алдаа, анхдагчуудаас дамжуулах 4-20 mA-н сигналуудын зөрүүг арилгана.
12. Хэмжилтийн үйл ажиллагаанд батлагдсан "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах" хууль, аргачлал, стандартуудыг мөрдөнө.
13. Ажлын байранд Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Техник ашиглалтын дүрэм, Аюулгүй ажиллагааны дүрэм зэрэг эрчим хүчний байгууллагуудад өдөр тутам мөрдөгдөх дүрэм, заавруудыг мөрдөж ажиллана.
14. Амгалан дулааны станцын захиргаанаас батлан гаргасан дүрэм, журам, заавруудыг ажлын байранд мөрдөнө.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны A/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p> Ш.Баянмөнх</p> <p>Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p>
<p>ХЯНАСАН: ДХХА-ийн хэсгийн инженер  С.Доржнамжиг</p> <p>Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн  Г.Саруул</p> <p>ХАБЭА-ийн инженер  А.Энхжаргал</p>	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН
НЭГДСЭН ЦЕХИЙН ДХХА-ИЙН ХЭСГИЙН ДХХА-ИЙН ЗАСВАРЧИНЫ
ҮІ ЗЭРГИЙН АЖЛЫН БАЙРНЫ ТАРИФ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ-7126-21**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Эрчим хүчний инженерийн бакалавраас доошгүй зэрэгтэй, тухайн албан тушаалд 6 ба түүнээс дээш жил ажилласан, тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж үнэлэлт гаргах, орчин үеийн техник хэрэгслийг ажлын байранд сайн ашиглах, харилцааны ур чадвартай, гарч буй өөрчлөлтөнд зохицон ажиллах чадвартай байх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, дулаан даралтын шалгалт тохируулгын эрхтэй, зураг схем унших чадвартай байх.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Онц нарийн ажиллагаа схемтэй, электрон, автомат аппаратур, хэмжих хэрэгслүүд, радио цацагт хэрэгслэл, фото элемент зэргийн засвар угсралт, шалгалт туршилт тохируулах ажил. Дулааны хяналт, хэмжилт, автомат тохируулгын онцгой нарийн төвөгтэй схем, ажиллагаа бүхий хэмжүүр, аппратуруудын гэмтлийг илрүүлэх, засварлах. Шалгалт тохируулгын нарийн багаж хэмжих хэрэгслийг засах, шалгаж тохируулах. Үндсэн болон туслах тоноглолын дулааны хянах хэмжүүр, автоматикийн хэрэгслүүдэд монтажийн иж бүрэн шалгалт туршилт хийж шалгаж тохируулах. Дулааны автоматикийн хэрэгслүүдийг шалгах схемийг цуглувалж угсрах. Өөрөөсөө доогуур зэрэгтэй засварчдын гүйцэтгэж чадаагүй ажилд зөвлөгөө өгөх, дулааны тоолуур ба автомат монтажлах ажилд бригад удирдан ажиллах.




МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

Физик, механик, дулааны техник, цахилгаан техник, электрон техникийн онол, дулааны хэмжүүр автоматикийн онцгой нарийн схем, хэмжүүрийн засвар, монтажийн ажлыг гүйцэтгэх технологийн дэс дараалал. Дулааны хэмжүүр, автомат тохируулагчийн засвар монтажинд шаардагдах материал, сэлбэг багаж хэрэгслүүдийн шинж чанар, түүнийг сонгон авах арга. Дулааны тоолуур, автоматын монтажлах засварын үед бригад удирдан ажиллах арга барилыг эзэмшсэн байх. Мөн Эрчим хүчний үйлдвэрүүдэд мөрдөгдөх ТАД, ААД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм журам, "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах" хууль, аргачлал, стандартууд, компанийн Хөдөлмөрийн дотоод журам, компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм журам, "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах" хууль, аргачлал, стандартууд, Эрчим хүчний салбартаа мөрдөгддөг бусад хууль тогтоомж.

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Ажиллаж байгаа тоноглолын дулааны хэмжүүр, автоматикийг ажиллагаанд залгаж тохируулна.
2. Электроникийн гэмтэл доголдлыг засварлаж тохируулна.
3. Хими анализын хэмжүүрүүдийг монтажлах, тохируулна.
4. Онцгой нарийн потенциометрийг засварлана.
5. Даралтын манометрийн хөдлөх системийн рамыг тооцоолж хийнэ.

6. Үлгэрлүүлсэн цахилгаан схемээс монтаж коммутацийн схемийг зурж гаргана.
7. Эсэргүүцлийн төрмөтээр ороох, тасархайг гагнаж залгана.
8. Хэмжилт шалгалтын олон ажиллагаат хэмжүүрийг /тестры/ засварлана.
9. Соронзон ёсгөгчийг засварлана.
10. Дулааны хэмжилт автоматжуулалтын үлгэрчилсэн схемийн дагуу хэмжилт хийх газрыг сонгох, анхдагч хэмжих хэрэгсэл арматурыг зоох угсарна.
11. Электрон автомат түвшин хэмжигчүүдийг угсрах, засварлах, турших, тохируулна.
12. Хэмжилтийн үйл ажиллагаанд батлагдсан "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах" хууль, аргачлал, стандартуудыг мөрдөнө.
13. Ажлын байранд Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Техник ашиглалтын дүрэм, Аюулгүй ажиллагааны дүрэм зэрэг эрчим хүчний байгууллагуудад өдөр тутам мөрдөгдөх дүрэм, заавруудыг мөрдөж ажиллана.
14. Амгалан дулааны станцын захиргаанаас батлан гаргасан дүрэм, журам, заавруудыг ажлын байранд мөрдөнө.
15. Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск/-ийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөж ажиллана.
16. Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолт, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусламж үзүүлэх заавруудаар тогтсон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p> Ш.Баянмөнх</p> <p>Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p>
<p>ХЯНАСАН: ДХХА-ийн хэсгийн инженер  С.Доржнамжиг</p> <p>Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн  Г.Саруул</p> <p>ХАБЭА-ийн инженер  А.Энхжаргал</p>	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН НЭГДСЭН ЦЕХИЙН ЦАХИЛГААНЫ
ХЭСГИЙН ЦАХИЛГААНЧИНЫ III ЗЭРГИЙН АЖЛЫН БАЙРНЫ
ТАРИФ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ-7412-21**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой, Эрчим хүчний хөгжлийн төв, ЭХСТөвд цахилгааны чиглэлээр суралцаж төгссөн байх цахилгааны аюулгүй ажиллагааны эрх олгох сургалтад хамрагдаж цахилгааны аюулгүй ажиллагааны III зэргийн группын үнэмлэхжсэн, цахилгааны аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Ээлжийн хугацаанд дулааны станцын цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг кабелийн аж ахуйн ба хуваарилах байгууламж, зуух болон дулааны тоног төхөөрөмжийн технологийн дохиолол ба хамгаалалт, бусад цахилгаан тоноглолд гарсан гэмтлийг хурдан шуурхай устгаж, цахилгаан, дулааны тоноглолын хэвийн ажиллагааг хангаж ажиллана. 1000В хүртэлх хүчдлийн дотоод хэрэгцээний цахилгаан тоноглолд шуурхай сэлгэн залгалтыг ААД, ТАД, ГАУСД-ын дагуу хийх, гэмтэл илрүүлэх, тодорхойлох, гарсан аваарийг устгахад оролцох, хоёрдогч хэлхээний бага хэмжээний bogino хугацаанд устгах гэмтлийг арилгах, цахилгааны хуваарилах байгууламжууд болон цахилгаан тоног төхөөрөмжүүдэд эргэлт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг шууд удирдлагад мэдэгдэж холбогдох ажилтаны хамт хэвийн болгож, тоноглолын хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллана. Нэгдсэн цехийн дарга, цахилгааны инженерийн шууд удирдлагад ажиллана. Ээлжинд ажиллаж буй бол СЭИ-ийн шууд удирдлагад ажиллана.

МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

Цахилгаан техникийн онолын үндсүүд, цахилгааны нарийн төвөгтэй багаж хэрэгслүүдийн бүтэц ажиллах зарчим, цахилгаан тоноглолуудын байгууламж, ажиллах зарчим, цахилгааны анхдагч болон хоёрдогч схем, дулаан цахилгааны эрчим хүч боловсруулах технологи процесс, РХА-ийн үндэс, үйлчилж байгаа тоноглолын цахилгаан техникийн болон механикийн үндэс, цахилгаан соронзон хоригийн схем, реле хамгаалалт, автоматикийн ажиллах зарчим, тэдгээрийн үйлчилгээний хүрээ, дэд станцад хэрэглэгдэж байгаа хамгаалах хэрэгсэл, тоноглолын туршилтын хугацаа, дэд станцад байрлуулсан холбооны төрөл, тэдгээрийн ажиллах журам. Мөн Эрчим хүчний үйлдвэрүүдэд мөрдөгдөх ТАД, ААД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, зарлан мэдээллэх систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, компанийн хэмжээнд мөрддөг дүрэм, журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийг мэдэж байх үүрэгтэй. Бүх төрлийн таслуур, автомат, соронzon пускателийн ажиллах зарчмыг мэддэг байх. 10/0.4кВ-ын хуваарилах байгууламж, тэдгээрээс тэжээгдэж буй хэрэглэгчидийг мэддэг байх. Асинхрон, синхрон хөдөлгүүр, тэдгээрийн ялгаа, тогтмол гүйдлийн цахилгаан хөдөлгүүр, ОРУ-110/10кВ-ын элегаз таслуурын үүрэг зорилго, зуухны үндсэн ба туслах тоноглолууд, технологийн хориг, тогтмол гүйдлийн эх үүсгүүрүүд, тогтмол гүйдлийн щитний схем, аккумуляторын батарей, цэнэглэх төхөөрөмжийн ажиллах зарчим, үүрэг зориулалт.

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг кабелийн аж ахуйн бүх хуваарилах байгууламж, зуух болон дулааны тоног төхөөрөмжийн технологийн дохиолол ба хамгаалалт, бусад цахилгаан тоноглог гарсан жижиг гэмтлүүдийг устгаж тэдний найдвартай ажиллагаа хангана.
2. Ээлжийн монтёр нь өөрөө устгаж чадахааргүй том гэмтлүүдийн талаар цахилгааны инженерт яаралтай мэдэгдэнэ.
3. Цахилгаан тоноглолд засвар үйлчилгээ хийнэ.
4. Бүх цахилгаан тоноглолд эргэлт шалгалтыг ээлжиндээ 2-оос доошгүй удаа хийж, тэмдэглэл хөтлөнө.
5. Эргэлт хийх үедээ ээлжийн монтёр нь хариуцсан бүх тоноглолуудаа нарийн үзлэг хийх ёстой ба дараах зүйлүүдийг онцгой анхаарна. Үүнд:
 - Хөдөлгүүр хэт ачаалагдаж байгаа эсэх.
 - Хөдөлгүүрийн холхивч, статорын халалтыг үзэх.
 - Хөдөлгүүрийн холхивчийн тос хэвийн байгаа эсэхийг үзэх.
 - Хөдөлгүүрүүдэд доргио байгаа эсэх.
 - Хөдөлгүүрийн гүйдэл дамжуулах хэсэг ба кабелийн сборка, шийдвэрлэлийн клемнүүдэд контактын халалт байгаа эсэх.
 - Хуваарилах байгууламжууд ба удирдлагын өрөөнүүдэд тавигдсан хамгаалах хэрэгсэл ба гал унтраах төхөөрөмж бүрэн бүтэн байгаа эсэхийг шалгах /резин бээлий, галош, штанг, галын хорнууд гэх мэт/
 - Хуваарыт тоноглол ба хуваарилах байгууламжид үзлэг, шалгах цэвэрлэгээ, чангалаа хийж байх.
 - Эргэлтийн үед ашиглалтанд байгаа тоног төхөөрөмжийн схеми гэмтлийг ээлжийн инженерт яаралтай мэдэгдэж байх.
 - Гэрэлтүүлгийн сүлжээнд зөөврийн гэрэл, түр зуурын холболт, зэлжийн инженерийн зөвшөөрөлгүй өөрөө хийхийг хориглоно.
 - Техник ашиглалтын шаардлага хангаагүй гэрэлтүүлгийн болон зөөврийн багаж хэрэгсэлийг холбохыг хориглоно.
 - Гэрэлтүүлгийн болон зөөврийн багаж хэрэгсэлийг зориулалтад бус газраас холбохыг хориглоно.
 - Өөрийн хариуцсан багаж хэрэгсэлийн бүрэн байдлыг хариуцана.
6. Ээлжийн цахилгаанчин нь цахилгаан тоног төхөөрөмжийн горхмын ажиллагаанд хяналт тавьж, гарсан гэмтэл saatlyg хэвийн болгоно.
7. Цахилгааны сэлгэн залгалтыг зааврын дагуу хийнэ.
8. 0.4кВ-ын хүчний схемийг цуглуулж, задлана.
9. Мегометр, амперклеш, бүх төрлийн хүчдэл заагчууд, тэдгээрт харьцаж, ажиллана.
10. Блокийн болон дотоод хэрэгцээний трансформатор, хаалтад хуваарилах байгууламжуудын тэжээлийн трансформатор, инверторын трансформаторууд дээр ажиллана.
- 11.Хуваарилах байгууламж, трассын цэвэрлэгээг хуваарийн дахь цэвэрлэнэ.
- 12.Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолт, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, галош, аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусламж үзүүлэлт, заавруудаар тогтсон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.
- 13.Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск-/ийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дахь цэвэрлэнэ.

хэрэглэнэ. ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөж ажиллана.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p>Ш.Баянмөнх</p> <p> 1115213380 д. 0021043</p> <p>Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p>
<p>ХЯНАСАН: Цахилгааны инженер Ц.Зэлмэ</p> <p>Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн </p> <p>ХАБЭА-ийн инженер  А.Энхжаргал</p>	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН НЭГДСЭН ЦЕХИЙН ЦАХИЛГААНЫ
ХЭСГИЙН ЦАХИЛГААНЧИНЫ IY ЗЭРГИЙН АЖЛЫН БАЙРНЫ
ТАРИФ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ-7412-21**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой, мэргэжлээрээ 1-ээс дээш жил ажилласан ажлын туршлагатай байх, цахилгааны аюулгүй ажиллагааны эрх олгох сургалтад хамрагдаж цахилгааны аюулгүй ажиллагааны III ба түүнээс дээш зэргийн группын үнэмлэхжсэн, цахилгааны аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ:

Ээлжийн хугацаанд дулааны станцын цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг кабелийн аж ахуйн ба хуваарилах байгууламж, зуух болон дулааны тоног төхөөрөмжийн технологийн дохиолол ба хамгаалалт, бусад цахилгаан тоноглолд гарсан гэмтлийг хурдан шуурхай устгаж, цахилгаан, дулааны тоноглолын хэвийн ажиллагааг хангаж ажиллана. 1000В ба түүнээс дээш хүчдлийн дотоод хэрэгцээний цахилгаан тоноглолд шуурхай сэлгэн залгалтыг ААД, ТАД, ГАУСД-ын дагуу хийх, гэмтэл илрүүлэх тодорхойлох, гарсан аваарийг устгахад оролцох, хоёрдогч хэлхээний бага хэмжээний богино хугацаанд устгах гэмтлийг арилгах, цахилгааны хуваарилах байгууламжууд болон цахилгаан тоног төхөөрөмжүүдэд эргэлт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг шууд удирдлагад мэдэгдэн холбогдох хүмүүсийн хамт тоноглолын хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллана. Нэгдсэн цехийн дарга, цахилгааны инженерийн шууд удирдлагад ажиллана. Ээлжинд ажиллаж буй бол СЭИ-ийн шууд удирдлагад ажиллана.

МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

Цахилгаан техникийн онолын үндэс, станцын дотоод хэрэгцээний цахилгаан тоног төхөөрөмжийн бүтэц, ажиллах зарчим, дотоод хэрэгцээний цахилгааны схем, станцын үндсэн ба туслах тоноглолын ажиллах зарчим, зориулалт, хамгаалалтын зарчим. Мөн Эрчим хүчний үйлдвэрүүдэд мөрдөгдөх ТАД, ААД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, нарядын систем, зарлан мэдээллэх систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийг мэдэж байх үүрэгтэй. ОРУ-110/10кВ-ын элегаз таслуурын үүрэг зорилго, Бүх төрлийн Блокийн болон дотоод хэрэгцээний трансформатор, хаалттай хуваарилах байгууламжуудын тэжээлийн тарансформатор, инвертор конверторын трансформаторуудыг мэддэг байх, таслуур, автомат, соронзон пускателийн үүрэг зориулалтыг мэддэг байх, 10/0.4кВ-ын хуваарилах байгууламж, тэдгээрээс тэжээгдэж буй хэрэглэгчийг мэддэг байх, зуухны үндсэн ба туслах тоноглолууд, технологийн хориг мэддэг байх, тогтмол гүйдлийн эх үүсгүүрүүд мэддэг байх, тогтмол гүйдлийн щитний схем, асинхрон, синхрон, тогтмол гүйдлийн хөдөлгүүр, тэдгээрийн ялгааг мэддэг байх.

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг кабелийн аж ахуйн ба хуваарилах байгууламж, зуух болон дулааны тоног төхөөрөмжийн технологийн дохиолол ба хамгаалалт, бусад цахилгаан тоноглолд

гарсан жижиг гэмтлүүдийг устгаж тэдний найдвартай ажиллагааг хангана.

2. Ээлжийн цахилгаанчин нь өөрөө устгаж чадахааргүй том гэмтлүүдийн талаар цахилгааны инженерт яаралтай мэдэгдэнэ.
3. Засвар, үйлчилгээний хүмүүсийн цахилгаан тоноглолд засвар үйлчилгээ зөв хийж байгаа эсэхийг хянана.
4. Бүх цахилгаан тоноглолд эргэлт шалгалтыг ээлжиндээ 2-оос доошгүй удаа хийж, тэмдэглэл хөтлөнө.
5. Эргэлт хийх үедээ ээлжийн монтёр нь хариуцсан бүх тоноглолуудад нарийн үзлэг хийх ёстой ба дараах зүйлүүдийг онцгой анхаарна. Үүнд:
 - Хөдөлгүүр хэт ачаалагдаж байгаа эсэх.
 - Хөдөлгүүрийн холхивч, статорын халалтыг үзэх.
 - Хөдөлгүүрийн холхивчийн тос хэвийн байгаа эсэхийг үзэх.
 - Хөдөлгүүрүүдэд доргио байгаа эсэх.
 - Хөдөлгүүрийн гүйдэл дамжуулах хэсэг ба кабелийн сборка, шинь клемнүүдэд контакны халалт байгаа эсэх.
 - Хуваарилах байгууламж, удирдлагын өрөөнүүдэд тавигдсан хамгаалах хэрэгсэл ба гол унтраах төхөөрөмж бүрэн бүтэн байгаа эсэхийг шалгах /резин бээлий, галош, штанг, галын хорнууд гэх мэт/
 - Хуваарийн дагуу тоноглол ба хуваарилах байгууламжид үзлэг, шалгалт цэвэрлэгээ, чангалаа хийж байх.
 - Эргэлтийн үед ашиглалтанд байгаа тоног төхөөрөмжийн схемийн гэмтлийг ээлжийн инженерт яаралтай мэдэгдэж байх.
 - Гэрэлтүүлгийн сүлжээнд зөөврийн гэрэл, түр зуурын холболтыг ээлжийн инженерийн зөвшөөрөлгүй өөрөө хийхийг хориглоно.
 - Техник ашиглалтын шаардлага хангаагүй гэрэлтүүлгийн болон зөөврийн багаж хэрэгсэлийг холбохыг хориглоно.
 - Гэрэлтүүлгийн болон зөөврийн багаж хэрэгсэлийг зориулалтын бус газраас холбохыг хориглоно.
 - Өөрийн хариуцсан багаж хэрэгсэлийн бүрэн байдлыг хариуцана.
6. Ээлжийн цахилгаанчин нь цахилгаан тоног төхөөрөмжийн горим ажиллагаанд хяналт тавьж, гарсан гэмтэл saatlyg хэвийн болгоно.
7. Цахилгаан тоног төхөөрөмжинд сэлгэн залгалтыг зааврын дагуу хийх.
8. 10/0.4кВ-ын хүчний схемийг цуглуулж, задлана.
9. 10/0.4кВ-ын секцийг засварт гаргах, оруулах сэлгэн залгалтын ажилд оролцно.
10. Мегометр, амперклеш, бүх төрлийн хүчдэл заагчууд, тэдгээртэй харьцаж, ажиллана.
11. Аккумуляторын батарей, цэнэглэх төхөөрөмжийн ажиллах зарчим, үүрэг зориулалтыг мэддэг байх ба хэмжилт хийж, эргэлт шалгалт хийнэ.
12. ОРУ-110/10кВ-ын шуурхай сэлгэн залгалтын ажилд оролцно.
13. 110/10кВ Дулаан дэд станцад сэлгэн залгалтын ажлыг гүйцэтгэдэг байна.
14. Хуваарилах байгууламж, трассын цэвэрлэгээг хуваарийн дагуу цэвэрлэнэ.
15. Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолт, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар,

галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусlamж үзүүлэх заавруудаар тогтсон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.

16. Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск/-ийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөж ажиллана.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал</p>  <p>Ш.Баянмөнх</p> <p>Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p>
<p>ХЯНАСАН: Цахилгааны инженер</p> <p>Ц.Зэлмэ</p> <p>Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн</p>  <p>Г.Саруул</p> <p>ХАБЭА-ийн инженер</p>  <p>А.Энхжаргал</p>	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН НЭГДСЭН ЦЕХИЙН ЦАХИЛГААНЫ
ХЭСГИЙН ЦАХИЛГААНЧИНЫ ҮЗЭРГИЙН АЖЛЫН БАЙРНЫ
ТАРИФ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ-7412-21**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Цахилгааны чиглэлээр тусгай дунд ба түүнээс дээш боловсролтой, мэргэжлээрээ 2 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай байх, цахилгааны аюулгүй ажиллагааны эрх олгох сургалтад хамрагдаж цахилгааны аюулгүй ажиллагааны IY ба түүнээс дээш зэргийн группын үнэмлэхжсэн, цахилгааны аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Ээлжийн хугацаанд дулааны станцын цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг кабелийн аж ахуйн ба хуваарилах байгууламж, зуух болон дулааны тоног төхөөрөмжийн технологийн дохиолол ба хамгаалалт, бусад цахилгаан тоноглолд гарсан гэмтлийг хурдан шуурхай устгаж, цахилгаан, дулааны тоноглолын хэвийн ажиллагааг хангаж ажиллах, трансформатор, хуваарилах байгууламж, дотоод хэрэгцээний цахилгаан тоног төхөөрөмжуудийн удирдлага, хамгаалалт, автоматикийн байгууламжуудын ашиглалтанд хяналт тавьж хэвийн хэмнэлттэй ажиллагааг хангах, ИХБ-110/10кВ-ын тоноглолуудад эргэлт шалгалт хийж, тэдгээрийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, илэрсэн зөрчлийг шууд удирдлагад мэдэгдэж, холбогдох хүмүүсийн хамт хэвийн болгох, цахилгаан тоноглолуудыг таслах, залгах, ерөнхий схемд болон дотоод хэрэгцээний схемд бүх төрлийн сэлгэн залгалтыг ААД, ТАД, ГАУСД-ын дагуу хийх, цахилгаан тоноглолд гарсан гэмтлийг илрүүлж устгах, хэвийн схемд оруулах, Дэд станцын хуваарилах байгууламжинд горимын шуурхай сэлгэн залгалт хийнэ. Нэгдсэн цехийн дарга, цахилгааны инженерийн шууд удирдлагад ажиллана.

МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

Цахилгаан техникийн онолын үндсүүд, цахилгааны нарийн төвөгтэй багаж хэрэгслүүдийн бүтэц, ажиллах зарчим, цахилгаан тоноглолуудын байгууламж, ажиллах зарчим, цахилгааны анхдагч болон хоёрдогч схем, дулаан цахилгааны эрчим хүч боловсруулах технологи процесс, хүчдэл, гүйдлийн трансформаторуудын үүрэг зорилго, холболтын схем бүрэн мэддэг байх, хурай салгууруудын алсын удирдлагатай приводууд, тэдгээрийн ашиглалт удирдлага, тэжээлийн схемийг бүрэн судалж мэдсэн байх, РХА-ийн үндэс, үйлчилж байгаа тоноглолын цахилгаан техникийн болон механикийн үндэс, цахилгаан соронзон хоригийн схем, реле хамгаалалт, автоматикийн ажиллах зарчим, тэдгээрийн үйлчилгээний хүрээ дэд станцад хэрэглэгдэж байгаа хамгаалах хэрэгсэл, тоноглолын туршилтын хугацаа, дэд станцад байрлуулсан холбооны төрөл, тэдгээрийг ашиглах журам, V группын хэмжээнд аюулгүйн техникийн дүрэм цахилгаан техникийн үндсүүд. Мөн Эрчим хүчний үйлдвэрүүдэд мөрдөгдөх ТАД, ААД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, нарядын систем, харьцааны заавар, зарлан мэдээллэх систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийг мэдэж байх үүрэгтэй. Тоноглолын технологи горим, хориг хамгаалалтын схемийг мэддэг байх, станцад тавигдсан бүх төрлийн таслууруудын тохиргоо үйлчилгээний талаар тодорхой мэддэг байх

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Станцын цахилгааны хангамжийн схемүүдийг бүрэн мэддэг бөгөөд сэлгэн залгалт хийдэг байна.
2. 110/10 кВ-ын ИХБ, болон 10кВ-ын ХХБ-д сэлгэн залгалт хийх чадвартай байна.
3. Дотоод хэрэгцээний 10/0,4 кВ-ын секцийг засварт гаргах, хэвийн схемд оруулна.
4. Дотоод хэрэгцээний цахилгаан тоноглолтуудын АВР-ийн хэлхээ, удирдлагын хэлхээнд гарсан гэмтлийг устгана.
5. Цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг кабелийн аж ахуйн ба хуваарилах байгууламж, зуух болон дулааны тоног төхөөрөмжийн технологийн дохиолол ба хамгаалалт, бусад цахилгаан тоноглолд гарсан жижиг гэмтлүүдийг устгаж тэдний найдвартай ажиллагааг хангаж ажиллана.
6. Эргэлт хийх үедээ эзлжийн монтёр нь хариуцсан бүх тоноглолтуудад нарийн үзлэг хийх ёстой ба дараах зүйлүүдийг онцгой анхаарна. Үүнд:
 - Хөдөлгүүр хэт ачаалагдаж байгаа эсэх.
 - Хөдөлгүүрийн холхивч, статорын халалтыг үзэх.
 - Хөдөлгүүрийн холхивчийн тос хэвийн байгаа эсэхийг үзэх.
 - Хөдөлгүүрүүдэд доргио байгаа эсэх.
 - Хөдөлгүүрийн гүйдэл дамжуулах хэсэг ба кабелийн сборка, шинь клемнүүдэд контакны халалт байгаа эсэх.
 - Хуваарилах байгууламж, удирдлагын өрөөнүүдэд тавигдсан хамгаалах хэрэгсэл ба гол унтраах төхөөрөмж бүрэн бутэн байгаа эсэхийг шалгах /резин бээзлий, галош, штанг, галын хорнууд гэх мэт/
 - Хуваарийн дагуу тоноглол ба хуваарилах байгууламжид үзлэг, шалгалт цэвэрлэгээ, чангалаа хийж байх.
 - Эргэлтийн үед ашиглалтанд байгаа тоног төхөөрөмжийн схемийн гэмтлийг эзлжийн инженерт яаралтай мэдэгдэж байх.
 - Гэрэлтүүлийн сүлжээнд зөөврийн гэрэл, тур зуурын холболтыг эзлжийн инженерийн зөвшөөрөлгүй өөрөө хийхийг хориглоно.
 - Техник ашиглалтын шаардлага хангаагүй гэрэлтүүлийн болон зөөврийн багаж хэрэгсэлийг холбохыг хориглоно.
 - Гэрэлтүүлийн болон зөөврийн багаж хэрэгсэлийг зориулалтын бус газраас холбохыг хориглоно.
 - Өөрийн хариуцсан багаж хэрэгсэлийн бүрэн байдлыг хариуцана.
7. Тухайн эзлжинд гарах хугацаандaa хуваарилах байгууламж, удирдлагын самбар, өрөө тасалгааг бүрэн цэвэрлэн дараагийн эзлжинд хүлээлгэн өгнө.
8. Цахилгаан тоног төхөөрөмжийн горим ажиллагаанд хяналт тавьж, гарсан гэмтэл саатлыг засна.
9. Цахилгааны сэлгэн залгалтыг зааврын дагуу хийнэ.
10. Шуурхай ажиллагааны болон техникийн бичиг баримт хөтлөх гэмтлийн журнал хөтлөнө.
11. ИХБ-д тавигдсан аяnga зайлзуулах болон цэнэг шавхагчийн ажиллагааг шалгана.
12. Хуваарилах байгууламж, трассын цэвэрлэгээг хуваарийн дагуу цэвэрлэнэ.
13. Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолт, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусламж үзүүлэх заавруудаар тогтсон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.

14. Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск-/ ийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөж ажиллана.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал  Ш.Баянмөнх </p> <p>Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p>
<p>ХЯНАСАН: Цахилгааны инженер  Ц.Зэлмэ</p> <p>Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн  Г.Саруул</p> <p>ХАБЭА-ийн инженер  А.Энхжаргал</p>	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН НЭГДСЭН ЦЕХИЙН ЦАХИЛГААНЫ
ХЭСГИЙН ЦАХИЛГААНЧИНЫ ҮІ ЗЭРГИЙН АЖЛЫН БАЙРНЫ
ТАРИФ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ-7412-21**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Тусгай дунд ба түүнээс дээш боловсролтой, мэргэжлээрээ 6-аас дээш жил ажилласан байх, цахилгааны аюулгүй ажиллагааны эрх олгох сургалтад хамрагдаж цахилгааны аюулгүй ажиллагааны IV ба түүнээс дээш зэргийн группын үнэмлэх авсан байх, цахилгааны схем унших, холбох, хэмжих хэрэгслүүдэд дээр ажиллах чадвартай, бие даан шийдвэр гаргах, багаар ажиллах чадвартай, техник сэтгэлгээтэй, өөрийгөө хөгжүүлж тогтворт суурьшилтай ажиллах хүсэлтэй байх, цахилгааны аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Дулааны станцын цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг кабелийн аж ахуйн ба хуваарилах байгууламж, зуух болон дулааны тоног төхөөрөмжийн технологийн дохиолол ба хамгаалалт, бусад цахилгаан тоноглолд гарсан гэмтлийг хурдан шуурхай устгаж, цахилгаан, дулааны тоноглолын хэвийн ажиллагааг хангаж ажиллах, трансформатор, хуваарилах байгууламж, дотоод хэрэгцээний цахилгаан тоног төхөөрөмжүүдийн удирдлага, хамгаалалт, автоматикийн байгууламжуудын ашиглалтанд хяналт тавьж хэвийн хэмнэлттэй ажиллагааг хангах, ИХБ-110/10кВ-ын тоноглолуудаар эргэлт шалгалт хийж тэдгээрийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, илэрсэн зөрчлийг шууд удирдлагад мэдэгдэж, холбогдох хүмүүсээр устгуулах, цахилгаан тоноглолуудыг таслах, залгах, ерөнхий схемд болон дотоод хэрэгцээний схемд бүх төрлийн сэлгэн залгалтыг ААД, ТАД, ГАУСД-ын дагуу хийх, цахилгаан тоноглолд гарсан гэмтлийг илрүүлж устгах, устгуулах, Дэд станцын хуваарилах байгууламжинд горимын шуурхай сэлгэн залгалах хийх. Ажлын байрыг бэлтгэх, бригадуудад хяналт тавих, ажлын байрыг хүлээн авах, аваарийг устгах сэлгэн залгалах хийх. Нэгдсэн цехийн дарга, цахилгааны инженерийн шууд удирдлагад ажиллана. Ээлжинд ажиллаж буй бол станцын ээлжийн инженерийн шууд удирдлагад ажиллана.

МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:


Цахилгаан техникийн онолын үндсүүд, цахилгааны нарийн төвөгтэй багаж хэрэгслүүдийн бүтэц, ажиллах зарчим, цахилгаан тоноглолуудын байгууламж, ажиллах зарчим, цахилгааны анхдагч болон хоёрдогч схем, дулаан цахилгааны эрчим хүч боловсруулах технологи процесс, РХА-ийн үндэс, Үйлчилж байгаа тоноглолын цахилгаан техникийн болон механикийн үндэс, цахилгаан соронзон хоригийн схем, реле хамгаалалт, автоматикийн ажиллах зарчим, тэдгээрийн үйлчилгээний хүрээ дэд станцад хэрэглэгдэж байгаа хамгаалах хэрэгсэл, тоноглолын туршилтын хугацаа, дэд станцад байрлуулсан холбооны төрөл, тэдгээрийг ашиглах журам IV-VI группын хэмжээнд аюулгүйн техникийн дүрэм цахилгаан техникийн үндсүүд. Мөн Эрчим хүчний үйлдвэрүүдэд мөрдөгдөх ТАД, ААД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, нарядын систем, харьцааны заавар, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийг мэдэж байх үүрэгтэй. Хучдэл, гүйдлийн трансформаторуудын үүрэг зорилго. холболтын схем бүрэн мэддэг байх. Хуурай салгууруудын алсын удирдлагатай приводууд, тэдгээрийн ашиглалт удирдлага, тэжээлийн схемийг бүрэн

судалсан байх. Агаарын шугамуудын үндсэн ба бэлтгэл хамгаалалтын горимд өөрчлөлт оруулах журамыг мэддэг байх

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Станцын цахилгааны хангамжийн схемүүдийг бүрэн мэддэг бөгөөд сэлгэн залгалт хийнэ.
2. 110/10 кВ-ын ИХБ, болон 10кВ-ын ХХБ-д сэлгэн залгалт хийх чадвартай байна.
3. Дотоод хэрэгцээний 10/0,4 кВ-ын секцийг засварт гаргах, хэвийн схемд оруулна.
4. Дотоод хэрэгцээний цахилгаан тоноглолуудын АВР-ийн хэлхээ, удирдлагын хэлхээнд гарсан гэмтлийг устгана.
5. Цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтуулэг кабелийн аж ахуйн ба хуваарилах байгууламж, зуух болон дулааны тоног төхөөрөмжийн технологийн дохиолол ба хамгаалалт, бусад цахилгаан тоноглолд гарсан жижиг гэмтлүүдийг устгаж тэдний найдвартай ажиллагааг хангаж ажиллана.
6. Эргэлт хийх үедээ зэлжийн монтёр нь хариуцсан бүх тоноглолуудад нарийн үзлэг хийх ёстой ба дараах зүйлүүдийг онцгой анхаарна. Үүнд:
 - Хөдөлгүүр хэт ачаалагдаж байгаа эсэх.
 - Хөдөлгүүрийн холхивч, статорын халалтыг үзэх.
 - Хөдөлгүүрийн холхивчийн тос хэвийн байгаа эсэхийг үзэх.
 - Хөдөлгүүрүүдэд доргио байгаа эсэх.
 - Хөдөлгүүрийн гүйдэл дамжуулах хэсэг ба кабелийн сборка, шинь клемнүүдэд контакны халалт байгаа эсэх.
 - Хуваарилах байгууламж, удирдлагын өрөөнүүдэд тавигдсан хамгаалах хэрэгсэл ба гол унтраах төхөөрөмж бүрэн бүтэн байгаа эсэхийг шалгах /резин бээлий, галош, штанг, галын хорнууд гэх мэт/
 - Хуваарийн дагуу тоноглол ба хуваарилах байгууламжид үзлэг, шалгалт цэвэрлэгээ, чангалаа хийж байх.
 - Эргэлтийн үед ашиглалтанд байгаа тоног төхөөрөмжийн схемийн гэмтлийг зэлжийн инженерт яаралтай мэдэгдэж байх.
 - Гэрэлтуулгийн сүлжээнд зөөврийн гэрэл, түр зуурын холболтыг зэлжийн инженерийн зөвшөөрөлгүй өөрөө хийхийг хориглоно.
 - Техник ашиглалтын шаардлага хангаагүй гэрэлтуулгийн болон зөөврийн багаж хэрэгсэлийг холбоыг хориглоно.
 - Гэрэлтуулгийн болон зөөврийн багаж хэрэгсэлийг зориулалтын бус газраас холбоыг хориглоно.
 - Өөрийн хариуцсан багаж хэрэгсэлийн бүрэн байдлыг хариуцана.
7. Тухайн зэлжиннд гарах хугацаандaa хуваарилах байгууламж, удирдлагын самбар, өөрөө тасалгааг бүрэн цэвэрлэж, дараагийн зэлжиннд хулээлгэн өгнө.
8. Цахилгаан тоног төхөөрөмжийн горим ажиллагаанд хяналт тавьж, гарсан гэмтэл saatlyg хэвийн болгоно.
9. Цахилгааны салгэн залгалтыг зааврын дагуу хийнэ.
10. Шуурхай ажиллагааны болон техникийн бичиг баримтыг хөтлөнө.
11. ИХБ-д тавигдсан аянга зайлзуулах болон цэнэг шавхагчийн ажиллагааг шалгана.
12. Өөрийн хэрэгцээний щит, угсралт дээр түүнчлэн дэд станцын хуваарилах ил далд төхөөрөмжийн хоёрдогч коммутацийн сүлжээнд гарсан эвдрэл гэмтлийг арилгах бага хэмжээний болгино хугацаанд хийгдэх ажил гүйцэтгэнэ.
13. Хүчдэл, гүйдлийн трансформаторуудын холболтын схем дээр ажиллана.
14. Хуурай салгууруудын алсын удирдлагатай приводууд, тэдгээрийн ашиглалт удирдлага, тэжээлийн схем дээр ажиллана.
15. Агаарын шугамуудын үндсэн ба бэлтгэл хамгаалалтын горимд өөрчлөлт оруулах

16. Дэд станцын болон ХХБ-уудын тоноглолт туршилт, тохируулга хийнэ.
17. Хуваарилах байгууламж, трассын цэвэрлэгээг хуваарийн дагуу цэвэрлэнэ.
18. Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолт, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусламж үзүүлэх заавруудаар тогтсон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.
19. Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск-/ийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгдөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөж ажиллана.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал  Ш.Баянмөнх </p> <p>Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p>
<p>ХЯНАСАН: Цахилгааны инженер  Ц.Зэлмэ</p> <p>Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн  Г.Саруул</p> <p>ХАБЭА-ийн инженер  А.Энхжаргал</p>	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН НЭГДСЭН ЦЕХИЙН РЕЛЕ
ХАМГААЛЛАЛТ АВТОМАТИКИЙН МОНТЁРЫН III ЗЭРГИЙН АЖЛЫН
БАЙРНЫ ТАРИФ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ-7412-21**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

РХА, цахилгаан ба цахилгаан систем автоматжуулалтын инженерийн мэргэжилтэй, компьютерийн хэрэглээний программуудыг эзэмшсэн байх, техникийн болон цахилгааны зураг, схем унших, зурах чадвартай, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ:

Хоёрдогч хэлхээг, гүйдлийн трансформатор, таслуурын автомат, реле зэргийг задлах угсралт, шалгах, тохируулах, хоёрдогч хэлхээний маркировка хийх, гүйдэл, хүчдлийн трансформаторын туршилтын хэлхээ цуглуулах, хоёрдогч хэлхээнд гал хамгаалагч сонгон авах, текстолит хув, албоцемент, гетинакс гэх мэт хөндийрүүлэгчийн материалыг зургийн дагуу бэлтгэх, хамгаалалтын панелийг бэхлэх, байрлуулах, кабелийн гэмтэл арилгах, халуун гагнуур хийх, хөндийрүүлэгч сэргээх, эд ангийн зураг бүдүүвч (загвар) гаргах ба түүний дагуу ажил гүйцэтгэх, реле засварын ороомог ороо тогтмол гүйдлийн хэлхээний газардлага арилгах. Контактор, пускатель, удирдлагын бүх төрлийн түлхүүрийг засах тохируулах. Батлагдсан графикийн дагуу цэвэрлэгээ үйлчилгээ болон чангалаа хийнэ.

МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

Янз бүрийн реле, реле хамгаалалт автоматикийн ангилал, тэдгээрийн бүтэц, зориулалт, технологи ажиллагаа, шаардлага, сэлгэн залгах, ердийн (номиналь) таслах хязгаарын гүйдэл, ердийн (номиналь) хүчдэлд гал хамгаалагч сонгон авах, цахилгаан соронзон, удирдлагын хувьсах, тогтмол гүйдлийн эх үүсвэр, тэжээлийн бүдүүвч, тосон залгуурын залуур, гар, цахилгаан соронзон хийн таслуурын алсын удирдлага, хүчдэлийн хэмжих трансформатор хүчдэлийн багтаамжийн хуваагч, гүйдлийн трансформатор, хамгаалалт шалгах аппаратууд, гүйдэл, хүчдэл шалгах тохируулах аппаратууд, реле хамгаалалт, автоматик, хөндийрүүлэгчийн эсэргүүцэл зэргийг шалгах арга, реле автоматикийн аппарат, хэмжүүрийг нэмэгдүүлсэн хүчдэлээр турших, задлах угсралт арга, удирдлагын гүйдлийн хэлхээнд ба аккумляторын батарейн ажиллах горим, цахилгаан хөндийрүүлэгч материал, ороомгийн цахилгаан утас, кабель нэвтрэх, бүрхэх лак, нягтуулах тослох материалын тухай, Эрчим хүчний үйлдвэрүүдэд мөрдөгдөх ТАД, ААД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн Хөдөлмөрийн дотоод журам, компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийг мэдэж байх үүрэгтэй.

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Нам хүчдэлийн шугамын бэлтгэл тэжээлийн автомат залгагчийг тохируулна.
2. Автоматыг задлах, тохируулах, гэмтлийг арилгана.
3. Хийн реле, дахин залгагч плапаны мөнгөн усан контакт, гэрлийн шилний бүтэн эсэхийг шалгана.
4. Реле, хэмжүүр аппаратын эд ангийн втулк шахна.
5. Индукцийн ороомгийг дахин ороноо.
6. Залгах, таслах ороомгийн ажиллах хүчдлийг тохируулна.

7. Хугацааны релений ороомог солино.
8. Клемний хайрцагт үйлчилгээ хийнэ.
9. Хагас дамжуулагч багажуудыг задлах, угсрах шалгана.
10. Дамжлагын хугацааг шалгана.
11. SEL реле шалгах, дотоод холболтын хэлхээний гэмтэл арилгана.
12. Зэрэгцээ ба дараалал холболттой секцийн реастатыг засна.
13. Хүчдлийн трансформаторыг залгах, хэлхээг шалгана.
14. Таслуурын оруулгад байрласан гүйдлийн трансформаторын салбарлалтыг тодорхойлно.
15. Тогтмол гүйдлийн хэлхээний зодлага арилгана.
16. Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск/-ийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөж ажиллана.
17. Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тариф мэргэжлийн лавлах, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусламж үзүүлэх заавруудаар тогтоосон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p>Ш.Баянмөнх</p>  <p>Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p>
<p>ХЯНАСАН: РХА-ийн инженер</p> <p>Д.Мөнхдэл</p> <p>Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн</p> <p>Г.Саруул</p> <p>ХАБЭА-ийн инженер</p> <p>А.Энхжаргал</p>	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН НЭГДСЭН ЦЕХИЙН
РЕЛЕ ХАМГААЛЛАТ АВТОМАТИКИЙН МОНТЕРЫН ІҮ ЗЭРГИЙН
АЖЛЫН БАЙРНЫ ТАРИФ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ-7412-21**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

РХА, цахилгаан ба цахилгаан систем автоматжуулалтын инженер түүнтэй адилтгах мэргэжилтэй, мэргэжлээрээ 2 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай, компьютерийн хэрэглээний программуудыг эзэмшсэн байх, англи хэлтэй, микропроцессор, контроллерын программчлалын мэдлэгтэй, техникийн болон цахилгааны зураг, схем унших, өөрийн үүрэгт ажилд хариуцлагатай ханддаг, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Реле хамгаалалтын панелийг зураг, угсралтын бүдүүвчээр угсрах ба автоматик төхөөрөмжийн олон үет далд угсралт, дуудлага хийх. Эрэг шураг, шайб пурш, ачаа хязгаарлагч зэрэг жижиг эд ангиудыг солих, кинематик балансировка хийх, цахилгаан хэлхээ, кинематик механизмын гэмтэл арилгах, реле тохируулах, засах, цахилгаан соронзон, цахилгаан механик блокировкийн төхөөрөмж засах, релений механизм, дүүжлүүр тэнхлэг, контактыг өнгөлөх, хоёрдогч хэлхээний хөндийрүүлэгч турших, тосон залгуурын ба хэмжих трансформатор, автоматикийн төхөөрөмж, релений хамагаалалт зэргийг тохируулах, шалгах, туршилтын хэлхээ цуглуулах. Батлагдсан графикийн дагуу цэвэрлэгээ үйлчилгээ болон чангалаа хийнэ.


МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

Хувьсах ба тогтмол гүйдлийн цахилгаан техникийн үндэс, цахилгаан тоноғлолын гэмтлийн төрлүүд. Реле хамгаалалт, автоматикийн төхөөрөмж түүний селектив чанар. Реле хүчдэлийн трансформаторын ангилал, гүйдлийн трансформаторын нарийвчлал, зориулалт, бүтэц, ажиллах зарчим, тэдгээрийг задлах, угсрах, үйлчлэх тохируулах, шалгах арга, их гүйдлийг таслах, их гүйдлийн чиглэлийн хамгаалалт, автомат дахин залгагч, бэлтгэл тэжээлийн автомат залгагчийн үндсэн шаардлага, зориулалт, хамгаалалт, шалгах аппарат, хамгаалалтын иж бүрэн турших төхөөрөмжтэй харьцах түүний нийтлэг гэмтлийг устгах арга, Эрчим хүчний үйлдвэрүүдэд мөрдөгдөх ТАД, ААД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн Хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбартаа мөрдөгддөг бусад хууль тогтоомжийг мэдэж байх үүрэгтэй.

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Залуурын механизм тохируулах, шалгана.
2. Хийн хамгаалалтын таслах ажиллагааг шалгана.
3. Хяналтын дохионы кабелийн ил үзүүрийн резин дээрмаркийн хамгаалах бүрээс түрхэнэ.
4. SEL маркийн реле дээр тавилын төлөв харна.
5. Таслах хэсгийн механик тохируулга хийнэ.
6. Дуут болон гэрлэн дохионы хэмжүүр сонгох, байрлуулах, шалгана.
7. Гүйдлийн трансформаторын соронзон тодорхойлолтыг авна.

8. Удирдлагын тогтмол гүйдлийн сүлжээний хөндийрүүлэгч, шалгах төхөөрөмж байрлуулна.
9. Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолт, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусlamж үзүүлэх заавруудаар тогтсон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.
- 10.Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск/-ийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөж ажиллана.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p> Ш.Баянмөнх</p> <p>Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p>
<p>ХЯНАСАН: РХА-ийн инженер</p> <p> Д.Мөнхдөл</p> <p>Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн</p> <p> Г.Саруул</p> <p>ХАБЭА-ийн инженер</p> <p> А.Энхжаргал</p>	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН НЭГДСЭН ЦЕХИЙН
РЕЛЕ ХАМГААЛЛАЛТ АВТОМАТИКИЙН МОНТЕРЫН ҮЗЭРГИЙН
АЖЛЫН БАЙРНЫ ТАРИФ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ-7412-21**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

РХА, цахилгаан ба цахилгаан систем автоматжуулалтын инженер түүнтэй адилтгах мэргэжилтэй, мэргэжлээрээ 4 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай, компьютерийн хэрэглээний программуудыг бүрэн эзэмшсэн байх, англи хэлтэй, микропроцессор, контроллерын программчлалын бүрэн мэдлэгтэй, техникийн болон цахилгааны зураг, схем унших, зурах чадвартай, өөрийн үүрэгт ажилд хариуцлагатай ханддаг, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Реле хамгаалалт, автоматикийн аппарат, хэмжүүр, цахилгааны төвөгтэй хэлхээ бүхий тусгай төхөөрөмж, цахилгаан хөдөлгүүр, генератор, трансформатор, синхрон компенсатор, кабелийн сүлжээ, өндөр хүчний цахилгаан дамжуулах шугамын реле хамгаалалтын ороомог, релений хөдлөх системийн механизм зэргийг задлах, угсралт, тохируулах, шалгах, элэгдэл, гэмтлийг тодорхойлох эд ангийг солих, зэвнээс хамгаалах бүрээс хийх. Авцалдах релений аппаратыг тохируулах, засах. Генератор, трансформатор агаарын ба кабель шугамын реле хамгаалалтын тодорхойлолт авах, шалгах ажлыг техникийн удирдлагын дор гүйцэтгэхэд оролцох. Батлагдсан графикийн дагуу цэвэрлэгээ үйлчилгээ болон чангалаа хийнэ.

МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

Трансформатор, генератор, цахилгаан хөдөлгүүр, агаарын ба кабель шугам, хоёр дахь хэлхээ, цахилгаан техникийн төхөөрөмж, реле хамгаалалт, бүх төрлийн реле автоматикийн ажиллах горим, гэмтэх хэлбэр, тэдгээрийг засварлах, дэлгэмэл угсралтын схем, хүчдэлийн трансформатор, хамгаалалтын төхөөрөмжийг нэгээс нөгөөд шилжүүлэх, реле хамгаалалтын хэлхээнд ашигладаг гүйдлийн трансформатор, шууд үйлдлийн релетэй хамгаалалт, бүх төрлийн реле, их гүйдэл, таслах гүйдэл, их гүйдлийн чиглэлийн ялгавар хамгаалалт, өндөр үелзлэлийн хамгаалалт, генератор, трансформатор цахилгаан хөдөлгүүр, цахилгаан дамжуулах шугамын хамгаалалт, релений механик, цахилгааны хэсэг зэргийг тохируулах, задлах, засах угсралт, шалгах арга. Автомат дахин залгагч /АДЗ-/ийн зохион байгуулалт, төрөл, бэлтгэл тэжээлийн автомат залгагч /БАЗ-/ийн зориулалт, түүнд тавих үндсэн шаардлагууд, реле хамгаалалтын аппарат тохируулах үеийн геометрийн муруй байгуулах хязгаарын тооцоо, цахилгаан техникийн онол, Эрчим хүчний үйлдвэрүүдэд мөрдөгдөх ТАД, ААД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн Хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийг мэдэж байх үүрэгтэй.

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. АДЗ, БАЗ-ыг тааруулна.
2. Цахилгаан дамжуулах шугамын солбио, /дифференциал/ хамгаалалт шалгах, засна.

3. Суурилагдсан гүйдлийн трансформаторын трансформацлах коэффициентийг шалгана.
4. Дифференциал хамгаалалтыг тааруулна./шалгах түр зуурын хэлхээ цуглуулах/
5. Реле хамгаалалтын панелийн гаднаас үзлэг хийх, угсралтын гэмтэл илрүүлнэ.
6. Sel, NNari , MPLR маркийн релений хөдлөх системд үйлчилгээ хийнэ.
7. Sel, NNari , MPLR маркийн релений хөдлөх системийг задлах, угсрах, тохируулах ажлыг хийж гүйцэтгэнэ.
8. Засварын ба дохиоллын реле шалгана.
9. Засварын релег тохируулна.
10. Чадлын релений холболтын зөв бурууг шалгана.
11. Шууд үйлчилгээтэй релений механик хэсгийг шалгана.
12. Шугамын хамгаалалтын эсэргүүцлийн релений контактлах системийг тохируулна.
13. Хариуцсан инженериний удирдлаган дор гүйдлийн хэлхээний /чиглэлийн/ диаграммыг буулгах, анхдагч гүйдлээр шалгана.
14. Хугацааны релений цагны механизмд үзлэг шалгалт хийнэ.
15. Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолт, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусlamж үзүүлэх заавруудаар тогтсон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.
16. Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск/-ийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөж ажиллана.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны A/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал  Ш.Баянмөнх</p> <p>Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p>
<p>ХЯНАСАН: РХА-ийн инженер  Д.Мөнхдөл</p> <p>Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн  Г.Саруул</p> <p>ХАБЭА-ийн инженер  А.Энхжаргал</p>	

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН НЭГДСЭН ЦЕХИЙН РЕЛЕ
ХАМГААЛЛАЛТ АВТОМАТИКИЙН МОНТЁРҮН YI ЗЭРГИЙН АЖЛЫН
БАЙРНЫ ТАРИФ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ-7412-21**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

РХА, цахилгаан ба цахилгаан систем автоматжуулалтын инженер түүнтэй адилтгах мэргэжилтэй, мэргэжлээрээ б ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай, компьютерийн хэрэглээний программуудыг бүрэн эзэмшсэн байх, англи хэлтэй, микропроцессор, контроллерын программчлалын бүрэн мэдлэгтэй, техникийн болон цахилгааны зураг, схем унших, зурах чадвартай, өөрийн үүрэгт ажилд хариуцлагатай хандаг, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Реле хамгаалалт, автоматикийн аппарат, өндөр үелзлэлийн блок, төрөл бүрийн реле, хэмжүүр, аппаратын цахилгаан ба механик хэсэг, эд анги, хамгаалалтын панель, осциллограф, циллограф, өндөр үелзлэлийн хэмжүүр, генератор зэрэг хэмжих электрон аппарат, шалгах аппаратын гэмтэл илрүүлэх задлах, угсрах, тохируулах, ажиллуулах, туршилт хийх, хэлхээг цуглуулах. Реле хамгаалалт автоматикийг шалгах иж бүрэн төхөөрөмжийг ажиллуулах, удирдах , батлагдсан графикийн дагуу цэвэрлэгээ үйлчилгээ болон чангалаа хийнэ.

МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ:

Хоёрдогч коммутациын хэлхээ, автоматик, реле хамгаалалтын аппаратур, цахилгаан дамжуулах шугам, цахилгаан хөдөлгүүрүүд, трансформаторууд, цахилгаан машинууд бусад цахилгаан төхөөрөмжүүдийн холболтын схем, цуглуулгын щит, цахилгаан дамжуулах шугам, синхрон компенсатор, генераторын хамгаалалтанд тавих шаардлага, хориг /блокировка/-той байгууламж, схем, өндөр үелзлэлийн блокировкотой хамгаалалтын ажиллагааны зарчим, тохируулах, засах, турших арга, савлалт ба тогтоцын тухай, шилжилтийн горимын тухай, симметрийн ба симметрийн биш богино залгааны ба симметрийн дарааллын аргын элементүүд, шууд, эсрэг ноль дарааллын тухай ойлголт, автоматик, реле хамгаалалтын цахилгааны схем ба удирдлагын хэлхээний үзлэг шалгалт, засвартай холбогдсон цахилгааны тооцоолох арга. Цахилгаан, радио техник, механикийн онол, материалын физикийн шинж чанар, Эрчим хүчний үйлдвэрүүдэд мөрдөгдөх ТАД, ААД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн Хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийг мэдэж байх үүрэгтэй.

АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Тэжээгчийн шулуутгах блоконд үзлэг тохируулга хийнэ.
2. 220кв-ын шугамын алсын /дистационный/ хамгаалалтанд хэсэгчилсэн үзлэг хийнэ.
3. Трансформатор, генератор, щитний дифференциал хамгаалалтын реленүүд, хөндийрүүлэгчийг турших ба механик хэсгийг шалгах, дотоод үзлэг хийнэ.
4. Дифференциал фазны өндөр үелзлэлийн хамгаалалт, хамгаалалтын

- панелийн цуглуулга ба туршилтын блокын залгуурын байгууламжийг шалгана.
5. Үндсэн хамгаалалт дифференциал хамгаалалт, аппаратын ба релений механик хэсгийн бүрэн эсэхийг шалгана.
 6. Дифференциал фазын хамгаалалт-туйлт релег тохируулна.
 7. Хамгаалалт, туршилтын иж бүрэн байгууламж, удирдлагын засвар хийнэ.
 8. Чадлын чиглэлийн реле цахилгаан тодорхойлолтыг шалгана.
 9. Релег шалгах ба тохируулна.
 10. Релений механик хэсгийг шалгах ба тохируулна.
 11. Үелзлэлийн релений цахилгааны тодорхойлолтыг шалгах ба тохируулна.
 12. Хамгаалалтын ба автоматикийн релений харилцан үйлчилгээг шалгана.
 13. Sel, NNari, MPLR маркийн релений системд үйлчилгээ хийнэ.
 14. Sel, NNari, MPLR маркийн релений системийг задлах, угсрал, тохируулна.
 15. Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск/-ийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөж ажиллана.
 16. Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тариф мэргэжлийн лавлах, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусlamж үзүүлэх заавруудаар тогтоосон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.

<p>БОЛОВСРУУЛСАН: Гүйцэтгэх Захирлын 2018 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон Мэргэжил, албан тушаалын тариф мэргэжлийн лавлах боловсруулах ажлын хэсэг</p> <p>Боловсруулж дууссан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр.</p>	<p>БАТЛАВ: Амгалан дулааны станц ХХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p> Ш.Баянмөнх</p> <p>Баталсан огноо: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр.</p>
<p>ХЯНАСАН: РХА-ийн инженер</p> <p>Захиргаа, удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн</p> <p>ХАБЭА-ийн инженер</p>	<p> Д.Мөнхдөл</p> <p> Г.Саруул</p> <p> А.Энхжаргал</p>

**АМГАЛАН ДУЛААН СТАНЦ ХХК-ИЙН НЭГДСЭН ЦЕХИЙН ХИМИЙН
ХЭСГИЙН ХИМИЙН АППАРАТЧИНЫ III ЗЭРГИЙН АЖЛЫН БАЙРНЫ
ТАРИФ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ -8131-12**

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Бүрэн дунд боловролоос дээш зэрэгтэй, Эрчим хүчний сургалтын мэргэжил олгох курст хамрагдсан, дулааны техникийн бакалавр зэрэгтэй, дулаантехник болон хими ус боловсруулалтын технологийн мэдлэгтэй байх, тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж үнэлэлт гаргах, орчин үеийн техник хэрэгслийг ажлын байранд сайн ашиглах, харилцааны ур чадвартай, гарч буй өөрчлөлтөнд зохицон ажиллах чадвартай, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.

АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ:

Дулааны станц болон Дулааны шугам сүлжээний усны гадаад дотоод усны алдагдалыг нөхөх, чанарын шаардлага хангасан цэвэр усаар үйлдвэрийг тасралтгүй хангаж, эрчим хүчний техник ашиглалтын дүрэмд заагдсан нэмэлт усны чанарын нормыг мөрдөж ажиллах. Дулааны шугам сүлжээ, ус боловсруулах төхөөрөмжийг зөөлрүүлэх схемээр ион солилцооны аргаар ус цэвэрлэх процессыг гүйцэтгэх, химиин цэвэрлэсэн усанд чанарын нормын дагуу хяналт тавьж, дулааны шугам сүлжээний ТАД-ын усны чанарын нормын дагуу тасралтгүй найдвартай хангах.

МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ :

Ус зөөлрүүлэх тоноглолын технологийн схем, химиин аргаар ус зөөлрүүлэх процессын зорилго, шүүлтүүрүүдийн зохион байгуулалт, ажиллах зарчим, насос, бак зэрэг үйлчилж байгаа тоног төхөөрөмжийн зохион байгуулалт, ажиллах зарчим, зориулалт, зөөлрүүлэх, сэргээх, угаах зэрэг хими ус бэлтгэлийн үндсэн технологийн процессууд, тэдгээрийн горим, химиин бодис урвалжийн зориулалт, байршил, ус бэлтгэлийн төхөөрөмжийн ажиллагаанд химиин хяналт тавих журам, ерөнхий химиин энгийн мэдэгдэхүүн, шүүх материалын онцлог ялгаа, шинж чанар, хэмжээ, тоног төхөөрөмжийг үйлчлэх үеийн ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Дулааны станцын ерөнхий схем, үндсэн тоноглолуудын тип, марк, хүчин чадал, зориулалт, хими цехийн зорилго үүрэг, хими лабораторийн зорилго, Лабораторийн дотоод дүрэм, зуухны тогооны зохион байгуулалт, цэвэр ус гаргах, дээараторуудын ажиллагааны зарчим ялгаа, тавих хими хяналт /хийн нормууд O_2 , CO_2 /, тэжээлийн усны боловсруулалт, явагдах урвал, схем тохирулга хийх, а. Аммиак, б. ГидрO-X, тогооны усны боловсруулалт явагдах урвал, фосфат өгөх схем, нэмэлт усны горим барилт, тэжээлийн ус, сүлжээний усны чанарын норм, хими хяналтын тодорхойлолт хийх аргууд /хатуулаг, шүлтлэг, CO_2 , O_2 , PO^{2-}_4 , RH , IN^-_3 , Fe^{3+} г.м / Үе үеийн үлээлгийн зорилго, үлээлгийн схем, хими хяналтын багажууд дээр ажиллах зарчим /ФЭК, RH метр /, нэмэлт усанд орох урсгалууд схем, нэмэлт усны бүрэлдэхүүн, нэмэлт усны чанар алдагдахад авах арга хэмжээнүүд, тогооны усны чанар алдагдахад авах арга хэмжээнүүд, сүлжээний усны чанар муудахад авах арга хэмжээ, хөргөлтийн ус, дотоод хэрэгцээний усны чанар муудахад авах арга хэмжээ Сүлжээний ус, Нэмэлт усны схем, үлээлгэх хийх график, шинжилгээний журнал хөтлөх, хоногийн үзүүлэлт хөтлөх, хоногийн дундаж бодох, уур усны лаборантын тариф мэргэжлийн лавлах, Эрчим хүчний үйлдвэрт мөрдөх ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, Монгол улсын хууль тогтоомжууд, компанийн хөдөлмөрийн дотоод журам болон



компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журам.

ХИЙГДЭХ АЖЛЫН ЖИШЭЭ:

1. Хими ус бэлтгэлд ирж байгаа үүсгэвэр усны чанараас хамааруулан ус боловсруулах ажиллагааны схемийг сонгон хэвийн найдвартай ажиллуулана.
2. Ус боловсруулах төхөөрөмжүүдийн горимын карт мөрдөж ажиллана.
3. Дулааны станцыг нэмэлт усаар тасралтгүй найдвартай хангах үйл ажиллагааны хүрээнд шуурхай арга хэмжээг авч ажиллана.
4. Ус бэлтгэлийн технологийн усны шат дамжлага бүрийн усны шинжилгээг стандартын дагуу үнэн зөв хийж, норм зөрчигдсөн үед залруулах арга хэмжээ авч ажиллана.
5. Хаягдал ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг хариуцан нормт хэмжээнд барьж ажиллана.
6. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, техник ашиглалтын дүрэм, галын аюулгүйн дүрмүүдийг үйл ажиллагаандaa мөрдөж ажиллана.
7. Дулааны станцын үйлдвэрлэлийн процесст шаардлагатай нэмэлт усны нөөцийг бүрдүүлж үйлдвэрийг тасралтгүй хэвийн явуулана.
8. Ус боловсруулах механик шүүлтүүрүүдийг горимын картын дагуу ажиллуулж үүсгэвэр болон боловсруулсан усны шинж чанараас хамааруулан бүлэгнүүлэгч бодисын хэмжээг тохируулж хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллана.
9. Ус зөөлрүүлэх төхөөрөмж болон эсрэг осмосын төхөөрөмжийг горимын картын дагуу ажиллуулж, үүсгэвэр ус болон боловсруулсан усны шинж чанараас хамааруулан дозлох уусмалын хэмжээг тохируулж хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллана.
- 10.Хими ус бэлтгэлийн тоног төхөөрөмжид орж байгаа болон шат дамжлага бүрээс гарч байгаа усны чанарын шинжилгээг батлагдсан графикийн дагуу хийж, нэмэлт усны чанарын нормыг хангаж ажиллана.
- 11.Ус боловсруулах төхөөрөмжүүдийн дозлох системийн ажиллагааг усны шинж чанараас хамааруулан горимын дагуу ажиллуулна.
- 12.Хийгүйжүүлэх төхөөрөмж болон нүүрсхүчлийн хий ялгах төхөөрөмжүүдийг хэвийн ажиллуулж хүчилтөрөгчийн, нүүрсхүчлийг нормт хэмжээг барьж ажиллана.
- 13.Ус бэлтгэлийн горимын карт, усны чанарын үзүүлэлтээс хамааруулан шаардлагатай үед тоноглолыг зогсоож дахин цэнэглэх / сийрэгжилт, сэргээлт, угаалт/ ажлыг цаг алдалгүй чанартай хийж, ажиллагаанд бэлэн байлгана.
- 14.Тоноглолын ажиллагаанд догонд голдог гарагад гэмтэл зөрчлийг нарийн тогтоож, шалтгааныг гэмтлийн журналд тэмдэглэж, ээлжийн инженер холбогдох удирдлагадаа шуурхай мэдээлж хэвийн болгож ажиллана.
- 15.Шуурхай ажиллагааны хяналт мэдээллийн системийг бүрэн мөрдөж ажиллана.
- 16.Лаборант түр эзгүй үед үүрэгт шаардлагатай тохиолдолд шууд удирдлагын шийдвэрээ ажлыг орлон гүйцэтгэнэ.
- 17.Тоноглолыг засварт оруулахад ажиллах аюулгүй ажиллагааг хангаж /хүчдэл авахуулах, шугам хоолойн ус, уусмалыг бүрэн юулж/ ажлын байрыг цэвэрлэж засварын ажил хийх боломжийг бүрдүүлнэ.
- 18.Хариуцсан ажлын байранд шаардлагатай арга хэмжээг авч, үйл ажиллагааны процессыг ээлжийн инженерт болон шууд удирдлагадаа цаг алдагдалгүй өгч ажиллана.

19. Тоноглолын гэмтэл засварын ажлыг бүрэн хариуцаж, засвар үйлчилгээ дууссаны дараа хүлээн авч гүйцэтгэлийн талаар шууд удирдлага болон ээлжийн инженерт мэдээлж ажиллана.
20. Тоноглолын ажиллагааны үеийн параметрүүдийг хоногийн үзүүлэлтэнд хөтөлж, үйл ажиллагааны процессыг шуурхай ажиллагааны журнаалд тэмдэглэж холбогдох удирлагууддаа мэдээлж шаардлагатай арга хэмжээ авч ажиллана.
21. Технологийн усны тоолууруудын заалтыг цаг тухайд тэмдэглэж ус бэлтгэлд авсан болон боловсруулсан усны тооцооны баланс гаргаж танилцуулж ажиллана.
22. Ус боловсруулалтын шат дамжлага бүрийн усны зарцуулалтыг тэмдэглэж, дотоод хэрэгцээ болон боловсруулсан усны тооцоог хоног сараар гаргаж ажиллана.
23. Ээлжийн хугацаанд зарцуулсан давсны бүртгэлийг тогтмол хөтөлж, зарцуулалтыг тайлagnаж ажиллана.
24. Ажлын байрыг байнга эмх цэгцтэй байлгаж, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж ажиллана.
25. Машин, тоног төхөөрөмжийг суурилуулах, үйл ажиллагааг эхлэх, удирдах, тохируулах, зогсоож ажиллана.
26. Аюулгүй ажиллагааны дүрэм, журмын дагуу бүтээгдэхүүний химийн урвал, өөрчлөлтийг хянана.
27. Холигч, хатаагч, нунтаглагч, үрэл хийгч болон бүрэх машин, тоног төхөөрөмж зэрэг нэг ба түүнээс олон химийн бодис, тогтоосон нэгж, норм, орц, сав, багажны хэмжүүр, тусгайлсан хэмжих багажны болон цахим багажны заалтыг хянана.
28. Тогтоосон нэгж, норм, орцын дагуу химийн бодисны найрлага, орцыг хэмжих, жигнэх, машин, тоног төхөөрөмжинд хийнэ.
29. Бүтээгдэхүүний дээж авах, өдөр тутмын химийн болон физикийн туршилтыг хийх, үйлдвэрлэлийн тэмдэглэл, мэдээллийг хөтлөнө.
30. Машин, тоног төхөөрөмжийг цэвэрлэх, бага зэргийн эвдрэл гэмтлийг засах.
31. Ион солилцооны аргаар ус цэвэрлэх процессыг гүйцэтгэнэ.
32. Давсны уусмалаар ион солилцооны шүүлтуүрүүдийг сэргээх процессыг гүйцэтгэнэ.
33. Хянах хэмжих хэрэгслийн заалт буюу хими шинжилгээний үр дүнгээр усны горим тохируулах, параметрыг тохируулана.
34. Хүчил шүлтээр химийн цэвэр усыг боловсруулах процессыг гүйцэтгэж хяналт тавина.
35. Үйлчилж байгаад тоног төхөөрөмжинд зарцуулж байгаа хими реагентын зарцуулалтыг тооцно.
36. Дотоод хэрэгцээнд зарцуулж буй усны тооцоо хийнэ.
37. Ус бэлтгэлийн тоног төхөөрөмжийг явуулах, зогсоох, турших үйлдлийг ээлжийн даргын удирдлага дор гүйцэтгэнэ.
38. Гарсан аваарийг устгахад оролцено.
39. Шуурхай ажиллагааны бичиг баримт хөтлөнө.
40. Хувийн хамгаалах хэрэгсэл /хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск/-ийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. ААД, ТАД, ГАУСД, хяналт мэдээллийн систем, компанийн хөдөлмөрийн дотоод журам, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг бусад хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөж ажиллана.

41. Техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолт, тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, анхны тусlamж үзүүлэх заавруудаар тогтсон хугацаанд ээлжит шалгалтыг өгсөн байна.

